**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 26 өдөр Дугаар А/91 Булган сум

“Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аян
зарлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.4, 9.3.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX Хуралдааны XIX/08 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяныг 2024 оны 03 дугаар сарын 01-ээс 10 дүгээр сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд зарласугай.

2.“Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяныг зохион байгуулах ажлын удирдамжийг 1 дүгээр, ажлын төлөвлөгөө 2 дугаар, зардлын тооцоог 3 дугаар хавсралтаар тус тус батлсугай.

3.Аяныг нутаг дэвсгэрийн хэмжээнд чанарын өндөр түвшинд зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр), Цагдаагийн газар (дэд хурандаа Г.Ганбаяр), Эрүүл мэндийн газар (П.Оюунцэцэг), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан), Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Сум, орон нутагтаа аяныг зохион байгуулах ажлын хэсэг томилж, нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг оролцуулж, ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

5.Аяны хүрээнд зохион байгуулсан ажлын мэдээ, мэдээллийг улс, орон нутгийн хэмжээнд сурталчлан ажиллахыг Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба (Г.Алтанцэцэг)-д үүрэг болгосугай.

6.Аяныг зохион байгуулахад шаардлагатай 50,000,000 (тавин сая) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний “Хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах Цэвэр орчин аян, иргэдэд нөлөөллийн ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах” төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

7."Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяны хүрээнд зохион байгуулсан ажлын дүнг 2024 оны 06 дугаар сарын 15, 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын удирдлагын багийн хуралд танилцуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны
02 дугаар сарын 26-ны өдрийн А/91 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

ЦЭВЭР ОРЧИН-ЦЭМЦГЭР БУЛГАН" АЯНЫ УДИРДАМЖ

## Нэг. Аяны зорилго

"Байгаль орчныг хамгаалах тухай" хууль, "Хог хаягдлын тухай" хууль, аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, хог хаягдлыг багасгах, орчны бохирдол доройтлыг бууруулах ажлыг зохион байгуулж, хоггүй цэвэр сайхан орчныг бүрдүүлэхэд оршино.

## Хоёр. Хамрах хүрээ

Аймгийн хэмжээнд сум, баг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага

## Гурав. Хэрэгжүүлэх хугацаа

Аймгийн хэмжээнд "Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяныг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд зохион байгуулна.

## Дөрөв. Аяны үйл ажиллагааны чиглэл

Аяныг хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах, сургалт сурталчилгаа зохион байгуулах, хариуцлагын тогтолцоог хэвшүүлэх гэсэн чиглэлээр зохион байгуулна.

**Нэгдүгээр чиглэл: Хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах**

1.Төв суурин газарт нийтийн эзэмшлийн талбай, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах;

2.Сум, багуудад өвөлжөө, хаваржаа, бэлчээр, гол горхи, нуур цөөрмийн хог хаягдал, үхсэн малын сэг зэмийг цэвэрлэх (Сэг зэмийг устгах ажлыг сумын Мал эмнэлгийн газар хариуцан хийж гүйцэтгэх);

3.Улсын болон орон нутгийн чанартай авто зам, уул даваа, овоо тахилгын хог хаягдлыг цэвэрлэх

4.Эзэнгүй хог хаягдал, хууль бус хогийн цэгүүдийг цэвэрлэх, дарж булах;

5.Аймгийн баяр наадам, сумын ойн өмнө, хойно нийтийг хамарсан цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах;

6.Аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийн хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах;

**Хоёрдугаар чиглэл: Сургалт сурталчилгаа**

1.Аяныг сурталчлах олон нийтийг хамруулсан өдөрлөг, сурталчилгааны ажил зохион байгуулах;

2.Хог хаягдлын тухай хууль, хог хаягдлыг багасгах, ангилан ялгах, эргүүлэн ашиглах, гялгар уутны хэрэглээнээс татгалзах талаар сургалт зохион байгуулж, сурталчилгаа хийх;

3.Олон нийтийн цахим сүлжээгээр аяныг сурталчлан зохион байгуулж байгаа ажлын мэдээллийг олон нийтэд хүргэх;

4.Сумдад хүүхэд, залуучуудад экологийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байх;

**Гуравдугаар чиглэл: Хариуцлагын тогтолцоог хэвшүүлэх**

1.Хог хаягдалтай холбоотой зөрчлийг шийдвэрлэх ажлыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад ойлгуулан таниулах ажлыг сум бүр зохион байгуулах (Сум, багийн Засаг дарга, Цагдаа, Байгаль орчны хяналтын улсын байцаагч хариуцан гүйцэтгэх);

2.Олон нийтийн байцаагч ажиллуулж, аялагч жуулчдад зөвлөгөө өгөх, мөн ил задгай, зориулалтын бус газар хог хаягдал хаях, шатаах зөрчлүүдэд тогтмол хяналт тавих;

3.Хариуцлагын тогтолцоог хэвшүүлэх, сум, багийн Засаг дарга, цагдаа, байгаль орчны хяналтын Улсын байцаагч, зөрчил гаргагчдад оногдуулах торгууль, шийтгэврийн ажлыг эрчимжүүлэх;

**Тав. "Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяныг дүгнэх**

1.Сумдыг аяны хүрээнд зохион байгуулсан ажлаар нь дүгнэн байр эзлүүлнэ.

2.Аяны хүрээнд зохион байгуулсан ажлыг дүгнэхдээ зохион байгуулсан ажлын үр дүн, чанар, хог хаягдлыг багасгах, ангилан ялгах ажилд шинэлэг санаа гаргаж хэрэгжүүлсэн ажил, аж ахуйн нэгж, албан байгууллага, иргэд, аялал жуулчлалын аж ахуйн нэгж байгууллагыг татан оролцуулсан байдал зэргийг харгалзан дүгнэн аймгийн ЗДТГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлнэ.

Аймгийн Засаг даргын 2024 оны
02 дугаар сарын 26-ны өдрийн А/91 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

**ЦЭВЭР ОРЧИН-ЦЭМЦГЭР БУЛГАН" АЯНЫ ХҮРЭЭНД ХОГ ХАЯГДЛЫГ БАГАСГАХ ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ/2024 ОН/**

| Д/д | Авч хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний төлөвлөгөө | Хэрэгжүүлэх хугацаа | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэгч | Санхүүжих эх үүсвэр (сая.төг) | Шалгуур үзүүлэлт | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| **1.Удирдлага зохион байгуулалт, хамтын ажиллагааны чиглэлээр** | | | | | | | | |
| 1.1 | "Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяны төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх | 1.1.1.Аяны хүрээнд 2024 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг гарган аймгийн Засаг даргаар батлуулах | II/15-20 | БОАЖГ | ХБТХОХ | Үйл ажиллагаа гаар | Хугацаанд нь боловсруулж батлуулна. | Аяны төлөвлөгөөг батлуулсан байна. |
| | | 1.1.2.Аяны захирамж, ажлын төлөвлөгөөг сумын Засаг дарга нар, байгууллагын дарга нарт хүргүүлэх | II/28-30 | ХБТХОХ | БОАЖГ | Үйл ажиллагаа гаар | Хугацаанд нь хүргүүлсэн байна. | Сумдад аяны талаарх мэдээлэл хүрсэн байна. |
| | | 1.1.3.Сумд "Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяныг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх | III/1-X/31 | СЗДТГ | Багийн Засаг дарга, иргэд, ААНБ | Үйл ажиллагаа гаар | Нарийвчилсан төлөвлөгөө гаргаж ээзнжүүлсэн байна. | Аяныг чанартай сайн зохион байгуулсан байна. |
| 1.2 | "Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяны хүрээнд бүх нийтийн цэвэрлэгээний | 1.2.1. Хаврын цэвэрлэгээний ажлыг 2 сарын хугацаатай, баяр наадмын үеийн цэвэрлэгээг 2 удаа, намрын цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулах. | IV/05-VI/05, VII/04-15 VIII/10-15 IX/25-30 | БОАЖГ | СЗДТГ | 40.8 | Цаг хугацаанд нь чанартай сайн зохион байгуулна | Аймгийн хэмжээнд хатуу хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах ажил хийгдсэн байна. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг зохион байгуулах | 1.2.2.Зудын эрсдэлтэй холбоотой болон бусад шалтгаанаар зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг цэвэрлэх, халдваргүйжүүлэн устгах, ажлыг зохион байгуулах | IV/01-VII/01 | Аймгийн МЭГ, СЗДТГ, МЭҮТ | Малчид, иргэд | ОНТ | Ажлын хэсэг томилон цэвэрлэгээний ажлыг чанартай сайн зохион байгуулсан байна. | Малын сэг зэмийг дарж устгах газрыг сумын ИТХ, багийн ИнХ-аар тогтоолгож, тогтоосон цэгт устгалын ажлыг чанартай сайн хийж, орчны бохирдлыг багасгана. |
| 1.3 | Хог хаягдлын хуулийн дагуу үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах,ажлыг зохион байгуулах | 1.3.1.Үйлдвэрлэгч болон имдортлогч компаниудын гэрээт борлуулагч нартай сав баглаа боодлоо эргүүлэн татах гэрээ байгуулах | III/15-IV/15 | СЗДТГ | ААНБ | Үйл ажиллагаа гаар | Бүх гэрээт борлуулагч нартай гэрээ байгуулан ажиллана. | Хог хаягдлын хуулийн хэрэгжилт хангагдаж, хог хаягдлын цэгт хүргэх хог хаягдлын хэмжээ багасна. |
| | | 1.3.2.Хүнсний бүтээгдхүүн худалдан борлуулдаг ААНБ, иргэдийг нийгмийн хариуцлагын хүрээнд худалдан борлуулсан бүтээгдхүүний сав баглаа боодлыг буцаан авах талаар тодорхой ажил зохион байгуулах | I- IV улирал | СЗДТГ | ААНБ, иргэн | Үйл ажиллагаа гаар | Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг иргэн, ААНБ-ыг бүрэн хамруулна. | |
| 1.4 | Шатахуун түгээх станцуудтай гэрээ байгуулан ажиллах | 1.4.1.Шатахуун түгээх станцуудын дэргэд хог хаягдал ангилан хийдэг хогийн сав байрлуулж, үйлчлүүлсэн зорчин явагсдын хог хаягдлыг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах | Жилдээ | СЗДТГ | ААНБ, ШТС | ААНБ-ын хөрөнгө | ШТС-уудыг бүрэн хамруулсан байна. | Зорчин явагчид хог хаягдлаа хийх цэгтэй болж, эзэнгүй хог хаягдал багасна. |
| | | 1.4.2.Хогийн савны хог хаягдлыг тогтмол ачиж зайлуулах ажлыг зохион байгуулах | Жилдээ | ШТС | СЗДТГ | ААНБ-ын хөрөнгө | Гэрээ байгуулж, тогтмол ачиж, бүртгэл | Сумын ЗДТГ-тай гэрээ байгуулан хог хаягдлыг ачиж тээвэрлэнэ. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөтлөж, тайланд тусгасан байна. | |
| 1.5 | Орхон аймагтай гэрээ байгуулан ажиллах | 1.5.1.Хил залгаа сумдын нутаг дэвсгэрийн хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах ажлыг хамтран зохион байгуулах /Орхон, Бугат, Хангал, Сэлэнгэ сум/ | V- X сар | СЗДТГ | Булган, Орхон аймгийн ЗДТГ, БОАЖГ | ОНТ | Жилд 2-3 удаа зохион байгуулсан байна. | Хил залгаа нутаг дэвсгэрийн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулна. |
| 1.6. | Хог хаягдлын талаар хийсэн ажлын тайланг нэгтгэх, дүгнэх | 1.6.1.Хог хаягдлын талаар хийсэн ажлын тайланг сумдаас хагас, бүтэн жилээр авч нэгтгэн ХБТХОХ-т хүргүүлж, аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулна. | VI/05-15 X/15-25 | ХБТХОХ, БОАЖГ | СЗДТГ | Үйл ажиллагаа гаар | Хугацаанд нь хүргүүлж, танилцуулна. | Зохион байгуулсан ажлын үр дүнг мэдээлнэ. |
| | | 1.6.2.Сумдыг зохион байгуулсан ажлаар нь дүгнэн байр эзлүүлж, аймгийн ЗДТГ-ын Хяналт үнэлгээний хэлтэст хүргүүлнэ | XI/25-XII/01 | БОАЖГ | СЗДТГ | Үйл ажиллагаа гаар | Шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэнэ. | Сумын Засаг даргын ажлын гол үзүүлэлт болгон дүгнэж, байр эзлүүлнэ. |
| **2.Мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах талаар** | | | | | | | | |
| 2.1 | “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аян, хог хаягдлыг багасгах, цэвэрлэх ажлыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах | 2.1.1.Олон нийтийн ТВ-ээр “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аян, аяны хүрээнд зохион байгуулж байгаа ажлын талаар мэдээлэх | Аяны хугацаанд | АЗДТГ-ын ХМОНХА | БОАЖГ, СЗДТГ | ОНТ | 2 удаа | Зохион байгуулж байгаа үйл ажиллагааг улс, орон нутгийн хэмжээнд сурталчилна. |
| | | 2.1.2.Орон нутгийн ТВ-ээр хог хаягдлыг багасгах, ангилан ялгах талаар болон “Аяллын хоггүй аймаг” уриалгыг сурталчлах | V/01-X/01 | БОАЖГ СЗДТГ, ТҮА, | Сайхан Монгол ТВ | ОНТ | Сард 1-ээс доошгүй | Иргэд олон нийтэд мэдээлэл түгээнэ. |
| | | 2.1.3.Аялал жуулчлалын ААНБ-ууд амрагч, жуулчдад хог хаягдлыг багасгах талаар сурталчилгаа хийх | V/01-IX/01 | ААНБ | СЗДТГ | Үйл ажиллагаа гаар | Сурталчилгаа хийсэн амрагч, жуулчдын тоо | Амрагч, жуулчдад мэдээлэл түгээнэ. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2 | Цахим орчин, олон нутгийн сүлжээгээр сурталчлан таниулах | 2.2.1.Хог хаягдлыг ангилан ялгах, эргүүлэн ашиглах талаарх шторк, зурган мэдээлэл, санамжуудийг цахим орчноор сурталчлах | Аяны хугацаанд | БОАЖГ | СЗДТГ, ААНБ | Үйл ажиллагаагаар | Сард 2-оос доошгүй | Иргэд хог хаягдлыг багасгах, ангилан ялгах талаар тодорхой мэдлэгтэй болно. |
| 2.3 | Сургалт зохион байгуулах | 2.3.1.“Монголд зочлох жил”, “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяны хүрээнд аймгийн хэмжээнд орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөгөөг танилцуулж, аяныг сурталчилж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, өдөрлөг зохион байгуулах | III/11-V/01 | БОАЖГ | СЗДТГ | 9.2 | 16 сум,1 тосгонд | Сумдад байгаль орчныг хамгаалах, хог хаягдлыг багасгах талаар сургалт зохион байгуулж, аяны үйл ажиллагааг сурталчилна. |
| **3.Орчны доройтлыг бууруулж, эрүүл ахуйг сайжруулах үйл ажиллагаа** | | | | | | | | |
| 3.1 | “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяныг зохион байгуулах | 3.1.1.Сумын Засаг дарга, багийн Засаг даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хогийн савны ашиглалтыг сайжруулах заалтыг тусган хэрэгжүүлэх/Булган сум/ | I-IV улирал | Аймаг, сумын ЗДТГ | Сумын Засаг дарга, багийн Засаг дарга | Үйл ажиллагаагаар | Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан байна. | Хогийн савны ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулна. |
| | | 3.1.2.Булган сум ангилсан хогийг ачих хуваарь гарган, ТҮА тусд нь тээвэрлэх ажлыг тогтол зохион байгуулах | I-IV улирал | СЗДТГ, ТҮА | Иргэд, ААНБ | Үйл ажиллагаагаар | Хуваарь гаргаж, сард 1 удаа тээвэрлэнэ. | Дахин ашиглагдах хог хаягдлын нөөц бүрдэнэ. |
| | | 3.1.3.ТҮА ангилсан хог хаягдлыг преслэн дахин ашиглах ААНБ-д нийлүүлэх талаар ТҮА-ийн даргын гүйцэтгэлийн гэрээнд тусгаж, хэрэгжүүлэх | Сард нэг удаа преслэх | ТҮА | Булган СЗДТГ | Үйл ажиллагаагаар | Преслэгчийг ажилуулж,хог хаягдлыг преслэнэ. | Байгальд дарж булах хог хаягдлын хэмжээ тодорхой хэмжээгээр багасна.. |
| | | 3.1.4.Хог ангилан ялгах цехийн түрээслэгчтэй үйл ажиллагааг өргөжүүлэх, ангилсан хог хаягдлыг хүлээн авах ажлыг | I-IV улирал | Булган сумын ЗДТГ, ТҮА | ААНБ | Үйл ажиллагаагаар | Дахин ашигласан, болосруулсан бүтээгдхүүний хэмжээ нэр | Ангилсан хогийг бэлдэц болон эцсийн бүтээгдэхүүн болгох үйл |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сайжруулах гэрээ байгуулж, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх | | | | | төрөл нэмэгдсэн байна. | ажиллагаа сайжирна. |
| | | 3.1.5. Булган сумын нийтийн эзэмшлийн талбай, айл өрх, орон сууцны гаднах хогийн савыг засварлаж, өнгө үзэмжийг сайжруулах | IV/05-VI/05 | СЗДГ, ТҮА | ААНБ, иргэд | Үйл ажиллагаагаар | Хогийн савны тоо | Хогийн савны насжилт сайжирч, өнгө үзэмж нэмэгдэнэ. |
| | | 3.1.6.Булган сумын төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдлыг дарж булах ажлыг шат дараатай хэрэгжүүлэх | I-IIIулирал | АЗДТГ, БОАЖГ | ААНБ | 75.0 | Ажлын даалгаврын дагуу хийж гүйцэтгэнэ. | Төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдлыг дарж булах ажил хийгдсэн байна. |
| | | 3.1.7.Сумын төвийн айл өрхийг хог ангилах ялгах хогийн савтай болгох /Булган сум/ | I-II улирал | АЗДТГ | БОАЖГ, СЗДТГ | 190.0 | 200 ш хогийн сав хийгдэнэ. | Булган сумын гэр хорооллын 200 айл өрх хогийн савтай болно. |
| | | 3.187.Хөдөөгийн сумдын төвийн хогийн савыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах | I-II улирал | СЗДТГ | ААНБ | Сумын төсөв, ААНБ-ын хөрөнгө | Хогийн савны тоо | Стандартын шаардлага хангасан хогийн савтай болж, эзэнгүй хог хаягдал багасна. |
| | | 3.1.9.Сумд хог хаягдлыг ангилан ялгах ажлыг эрчимжүүлж, ангилсан хог хаягдлыг хүлээн авах цэгүүдийн тоог нэмэгдүүлж, үйл ажиллагааг жигдрүүлэх | Жилдээ | СЗДТГ | ААНБ, иргэд | Үйл ажиллагаагаар | 2 догч түүхий эд авах цэгийн үйл ажиллагааг жигдрүүлнэ. | Хог хаягдлыг ангилан ялгах боломж бүрдэж, байгальд хаягдах хог хаягдлын хэмжээ багасна. |
| | | 3.1.10.Ангилсан хог хаягдлыг тушаах газартай гэрээ байгуулан тогтсон хугацаанд ачиж тээвэрлэх ажлыг зохион байгуулах | Жилдээ | СЗДТГ | ААНБ, иргэд | Үйл ажиллагаагаар | Ангилж, тушаасан хог хаягдлын хэмжээ | Байгальд хаягдах хог хаягдлын хэмжээ багасна. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.1.11.Хаврын бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулан айл өрх, ААНБ өөрийн эзэмшил 50 м газрын хог хаягдлыг цэвэрлэн зайлуулж, хашаа, байрныхаа өнгө үзэмжийг сайжруулах | IV/05-VI/05 | БОАЖГ | СЗДТГ, ААНБ | ОНТ | Чанартай сайн зохион байгуулж, тайланд тусгана. | Хог хаягдлын тухай хуулийн 9.4.12, 9.5.2, 10.2.6 дахь заалтуудын хэрэгжилтийг хангуулна. |
| | | 3.1.12.Гол горхи, рашаан ус, нуур цөөрөм, уст цэгүүдийн орчны хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах | IV/05-V/25 | СЗДТГ, ААНБ | Иргэд | ОНТ | | Уст цэгүүдийн бохирдлыг багасгаж, бохирдлоос урьдчилан сэргийлнэ. |
| | | 3.1.13.Хог хаягдлыг багасгах, ангилан ялгах, дахин ашиглах талаар шинэ санаачлага, гарган хэрэгжүүлэх | IV/05-VI/05 | СЗДТГ | ААНБ, иргэд | Үйл ажиллагаа, сумын төсөв | | Олон нийтэд түгээн дэлгэрүүлэхүйц шинэ санаа санаачлага бүхий 2-оос доошгүй ажил зохион байгуулсан байна. |
| | | 3.1.14.Хөдөөний малчин айл өрхийг нүүхдээ буйраа цэвэрлэдэг уламжлалт зан заншлыг сэргээж, зун, намар нутагласан газрынхаа хог хаягдлыг цэвэрлэх /Багийн Засаг дарга, байгаль хамгаалагчдтай гэрээ хэлцэл байгуулах/ | Тухай бүр | СЗДТГ, Багийн Засаг дарга, байгаль хамгаалагч | Малчин өрх | Үйл ажиллагаагаар | Гэрээ, хэлцэл байгуулсан өрхийн тоо | Эзэнгүй хог хаягдал багсаж, орчны бохирдол буурна. |
| 3.2 | Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах | 3.2.1.Сумдад хатуу хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсэг томилох | III/05-10 | СЗДТГ | ААНБ | Үйл ажиллагаагаар | Сумын Засаг даргын захирамжаар томилсон байна. | Ажлыг ээнжүүлж, чанартай хийж гүйцэтгэнэ. |
| | | 3.2.2.Айл өрх, ААНБ-ын цэвэрлэсэн хог хаягдлыг | Тухай бүр | СЗДТГ, ААНБ | Иргэд | ОНТ | Хог хаягдал ачих график, хуваарь | Хуваарийн дагуу ачиж тээвэрлэнэ. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нэгдсэн журмаар ачиж хогийн төвлөрсөн цэгт хаях | | | | | гарган тээвэрлэх | |
| | | 3.2.3.Зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг цэвэрлэж, устгах, халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулах | IV/01-VII/01 | Аймгийн МЭГ, СЗДТГ, МЭҮТ | Малчид, иргэд | ОНТ | Сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилсон ажилласан байна. | Сум, багаас тогтоосон газарт малын сэг зэмийг дарж булан устгаж, зохион байгуулсан ажлын мэдээг тайланд тусгасан байна. |
| | | 3.2.4.Төв суурин газрын ойролцоох овоо тахилгын орчныг цэвэрлэж, тохижуулах | IV/05-VI/05 | СЗДТГ | ААНБ, Иргэд | ОНТ | Жилд 2-3 удаа | Олон нийтийг татан оролцуулж, чанартай сайн зохион байгуулж, тайланд тусгасан байна. |
| | | 3.2.5.Улсын болон орон нутгийн чанартай зам болон даваа, овоо тахилгын орчны цэвэрлэх | IV/15-V/25 IX/25-X/01 | СЗДТГ | ААНБ, Иргэд | ОНТ | Жилд 2-3 удаа | |
| | | 3.2.6.Хөдөөний багуудын айл өрхийн өвөлжөө, хаваржааны хог хаягдлыг цэвэрлэх | IV/15-V/25 | Багийн Засаг дарга | Малчин айл өрх | Өөрийн хөрөнгө | Багийн дарга, байгаль хам гаалагчтай гэрээ байгуулан гүйцэтгэсэн байна. | Малчдын хариуцлага сайжирч, орчны бохирдол багасна. |
| | | 3.2.7."Цэвэрхэн наадацгаая" уриан дор үндэсний баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулах | VI/25-VII/05, VII/15-VII/25 | СЗДТГ | ТҮА, ААНБ, иргэд | Үйл ажиллагаа аар | 2 удаа | Иргэд, ААНБ-ыг татан оролцуулж, Хог хаягдлын тухай хуулийн 9.4.12 дахь заалтын хэрэгжилтийг хангуулна |
| | | 3.2.8. Үерийн далан, суваг шуудууг цэвэрлэх | VI/10-VIII/10 | СЗДТГ | ААНБ, иргэд | ОНТ | 1 удаа | |
| | | 3.2.9.Сум, байгууллага бүр хийсэн ажлын тайлан мэдээг тоо баримт, фото зургаар | VI/05-10 X/15-20 | БОАЖГ | Сумын ЗДТГ | Үйл ажиллагаа аар | Үнэн зөв гаргаж, статистик | Аяны хүрээнд зохион байгуулсан ажлын мэдээллийг |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | баримтжуулан БОАЖГ-т ирүүлэх | | | | | мэдээллийн хамт ирүүлнэ. | нэгтгэн АЗДТГ-т хүргүүлнэ. |
| 3.3 | “Монголд зочлох жил”-ийн хүрээнд хог хаягдлыг багасгах ажлыг зохион байгуулах | 3.3.1.Сум бүр “Аяллын хоггүй аймаг уриалга”-ыг хэрэгжүүлж, Аялал жуулчлал, амралтын газруудтай гэрээ байгуулж, хог хаягдлыг багасгах төлөвлөгөө гарган сумын ЗДТГ-аар батлуулан ажиллах | Жилдээ | СЗДТГ | ААНБ, иргэд | Үйл ажиллагаагаар | Төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байна. | Хариуцлагын тогтолцоог сайжруулж, хамтран ажиллана. |
| | | 3.3.2.Амралт, аялал жуулчлалын газруудад хог хаягдлаа түр хадгалах цэг байгуулж, дахин ашиглах хог хаягдлыг ангилах ялгах ажлыг хэвшүүлэх | Жилдээ | ААНБ | СЗДТГ | Үйл ажиллагаагаар | Чанартай сайн зохион байгуулж, хийсэн ажлын мэдээг тайланд тусгана. | Орчны бохирдол багасна. |
| | | 3.3.3.Ангилсан хог хаягдлыг ангилсан хог хаягдлыг хүлээн авах цэгт хүргэх | Жилдээ | ААНБ, иргэд | СЗДТГ | Үйл ажиллагаагаар | | Байгальд хаягдах хог хаягдал багасна. |
| | | 3.3.4.Аялал жуулчлал, амралтын газрууд “Ирлээ, явлаа-Цэвэр” аян өрнүүлж, аялагч амрагчдад зориулсан сурталчилгааг хийх | Жилдээ | ААНБ | СЗДТГ | Үйл ажиллагаагаар | | Аялагч, амрагч нарт хог хаягдлын талаар зөв дадал хэвшил эзэмшүүлнэ. |
| | | 3.3.5.Аялал жуулчлал дагасан хог хаягдлын судалгаа гаргаж, цэвэрлэгээний ажлыг аяллын улиралд 3 удаа зохион байгуулах | V/20-V/25<br>VII/20-25<br>IX/20-25 | СЗДТГ, Аймгийн АЖХ | ААНБ, иргэд | ОНТ, Хувийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр | | Аялал жуулчлал дагасан хог хаягдлыг цэвэрлэж, рашаан, голын голдирол болон байгальд хаясан хог хаягдал багасч орчны бохирдол доройтол буурна. |
| | | 3.2.6.Хог хаягдлаа тогтсон хугацаанд тээвэрлэх ажлыг хэвшүүлэх | 7-10 хоног тутам | ААНБ | СЗДТГ | Үйл ажиллагаагаар | | Орчны бохирдол доройтол багасна. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.2.7.Аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийн үеэр хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах ажлыг зохион байгуулах | Тухай бүр | Зохион байгуулсан сумын ЗДТГ | БОАЖГ | ОНТ | | Эвент арга хэмжээг орчны бохирдолгүй зохион байгуулна. |
| | | 3.2.8.Аялал жуулчлалын эвент арга ариун цэврийн асуудлыг шийдвэрлэж, хөрс бохирдуулдаггүй жорлонг ашиглах | Тухай бүр | АЗДТГ, СЗДТГ | БОАЖГ, Булган сумын ТҮА, ААНБ | ОНТ | | |
| | | 3.2.9.Аялал жуулчлал, амралтын газруудын Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийх | VI/05-VIII/05 | БОАЖГ | СЗДТГ | ОНТ | Илэрч, арилгуулсан зөрчлийн тоо | Хог хаягдлы тухай хуулийн хэрэгжилтийг хангуулна. |
| 3.4 | Аюултай хог хаягдлын талаар | 3.4.1.Сумандаа байгаа Аюултай хог хаягдал, аюултай хог хаягдал үүсгэгчийн судалгааг гарган бүртгэлжүүлж, 06-р сарын 25-ны судалгааг БОАЖГ-т ирүүлэх | I-II улирал | СЗДТГ | ААНБ | Үйл ажиллагаагаар | Хугацаанд нь үнэн зөв гаргаж ирүүлнэ. | Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэл мэдээллийн сантай болно. |
| | | 3.4.2.Сумын БОХУБ, байгаль хамгаалагчид аюултай хог хаягдлын талаар иргэдэд сургалт, мэдээлэл хийх | I-II улирал | СЗДТГ, БОХУБ, байгаль хамгаалагч | ААНБ, иргэд | Үйл ажиллагаагаар | Хийсэн ажлын мэдээг 7 хоногийн мэдээнд ирүүлсэн байна. | Иргэдэд аюултай хог хаягдлын талаар тодорхой мэдээлэл өгсөн байна. |
| 3.5 | "Жорлонгоо өөрчилье" аян, нүхэн жорлонг ариутган халдваргүйжүүлэх | 3.5.1.Сумын Засаг дарга нарт сумандаа үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, ААНБ-ын<br>3.5.1.1.Төр төсвийн байгууллагуудын ААНБ-ын нүхэн жорлонг байгальд ээлтэй боловсон | I-II улирал | СЗДТГ, БОХУБ, байгаль хамгаалагч | ААНБ, иргэд | ОНТ, ААНБ-ын хөрөнгө | Жорлонгийн тоо | Нүхэн жорлонг буулгаж, хөрс, ус, орчны бохирдлыг багасгана. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | жорлонгийн судалгааг гаргаж, буулгах шаардлагатай жорлонгуудыг буулгаж, байгальд ээлтэй жорлон болгох ажлыг зохион байгуулж, хийсэн ажлын тайлан мэдээг 07-р сарын 05-ны дотор ирүүлэх албан бичиг хүргүүлэх | жорлон болгох | | | | | | |
| | | | 3.5.1.2. Аялал жуулчлал, рашаан, амралтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ын нүхэн жорлонг байгальд ээлтэй боловсон жорлон болгох | I-II улирал | СЗДТГ, БОХУБ, байгаль хамгаалагч | ААНБ, иргэд | ААНБ-ын өөрийн хөрөнгө | Жорлонгоо өөрчилсөн иргэн, ААН-ын тоо | Амрагч, аялагчдын тав тухыг хангаж, нүхэн жорлонг буулгаж, хөрс, ус, орчны бохирдлыг багасгана. |
| | | | 3.5.1.3. ШТС-уудын нүхэн жорлонг байгальд ээлтэй боловсон жорлон болгох | I-II улирал | СЗДТГ, БОХУБ, байгаль хамгаалагч | ААНБ | ААНБ өөрийн хөрөнгөөр | | Хөрс, ус, орчны бохирдол багасна. |
| | | | 3.5.1.4.Худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, ААНБ-ын нүхэн жорлонг байгальд ээлтэй боловсон | I-II улирал | СЗДТГ, БОХУБ, байгаль хамгаалагч | ААНБ,иргэн | Иргэн, ААНБ өөрийн хөрөнгөөр | | Орчны бохирдол буурч, эргүүл аюулгүй орчин бүрдэнэ. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | жорлон болгох | | | | | | |
| | | | 3.5.1.5. Гол, булаг шанд, рашаан усан сан бүхий газрын нүхэн жорлонг буулгаж, байгальд ээлтэй боловсон жорлон болгох ажлыг зохион байгуулах | II улирал | СЗДТГ, БОХУБ, байгаль хамгаалагч | Багийн Засаг дарга | Иргэн, ААНБ өөрийн хөрөнгөөр | Буулгаж, өөрчилсөн жорлонгийн тоо | Орчны бохирдол буурч, эргүүл аюулгүй орчин бүрдэнэ. |
| | | 3.5.2.Сум бүр айл өрх, албан байгууллагын нүхэн жорлонг ариутган халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулах | | II улирал | СЗДТГ, ЭМТ | Багийн Засаг дарга, айл өрх | Үйл ажиллагаагаар | Хамрагдсан айл өрхийн тоо | Орчны бохирдол буурч, эргүүл аюулгүй орчин бүрдэнэ. |
| 3.6 | Сумдад автомашин, техник нийлүүлэх | 3.6.1.Хог ачих зориулалтын авто машиныг 2 суманд нийлүүлнэ. | | I- II улирал | АЗДТГ, БОАЖГ | ААНБ | 260.0 | Техникийн тодорхойлол тонд заагдсны дагуу нийлүүлнэ | Булган, Хангал сум хог ачих автомашинтай болно. |
| | | 3.6.2. Бохир соруулах тоноглогдсон автомашиныг 3 суманд нийлүүлнэ. | | I- II улирал | АЗДТГ, БОАЖГ | ААНБ | 210.0 | | Булган, Баян-агт, Сэлэнгэ сум |
| | | 3.6.3. Хог түрж булах техник худалдан авах | | I- II улирал | АЗДТГ, БОАЖГ | | 320.0 | | Бугат, Тэшиг, Баян-Агт, Орхон сум хог түрж булах техниктэй болно. |

Аймгийн Засаг даргын 2024 оны
02 дугаар сарын 26-ны өдрийн А/91 дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт

## “ЦЭВЭР ОРЧИН-ЦЭМЦГЭР БУЛГАН” АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

| Д/д | Үйл ажиллагаа | Тоо хэмжээ | Зардал (Төг) | Төсөв (Төг) |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяныг зохион байгуулах (16 сум 1 тосгон) | 17 | 2 400 000 | 40 800 00 |
| 2 | “Монголд зочлох жил”, аяны хүрээнд аймгийн хэмжээнд орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөгөөг танилцуулж, аяныг сурталчилж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, өдөрлөг зохион байгуулах | 16 сум, 1 тосгон | Шатахуун, томилолт, сумдад өдөрлөг зохион байгуулах | 9 200 000 |
| | **Нийт** | | | **50 000 000** |

## Орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөгөөг танилцуулж, аяныг сурталчилж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, өдөрлөг зохион байгуулах зардлын задаргаа

| д/д | Зардлын төрөл | Хугацаа | Хэмжих нэгж | Нэгжийн зардал/төг/ | Тоо хэмжээ | Нийт /төг/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Томилолтын зардал | III/01-V/01 | Хүн/ хоног | 64 000 | 4/15 | 3 840 000 |
| 2 | Шатахууны зардал /ДТ/ | | 17л/100км | 3 950 | 280 | 1 108 000 |
| 3 | Хог хаягдлын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хог хаягдлыг багасгах, ангилах ялгах өдөрлөгийг сумын ЗДТГ,ТББ-тай хамтран зохион байгуулах | III/01-V/01 | 17 | 200 000 | 16 сум, 1 тосгонд | 3 400 000 |
| 4 | Гарын авлага хэвлүүлэх | II/15-III/01- | ш | 1 420 | 600 | 852 000 |
| | **Дүн** | | | | | **9 200 000** |

## Сургалт, сурталчилгаа, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлын маршрут, шатахууны тооцоо

| Д/д | Сумын нэр | Зай /км/ | Д-түлш-норм /л/ | Шатахууны хэмжээ /л/ | Нэгжийн үнэ /төг/ | Бүгд үнэ /төг/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Булган -Орхон | 22 | 17 | 3.74 | 3950 | |
| 2 | Орхон -Бүрэгхангай | 60 | 17 | 10.2 | 3950 | |
| 3 | Бүрэгхангай-Баяннуур | 100 | 17 | 17 | 3950 | |
| 4 | Баяннуур-Дашинчилэн | 35 | 17 | 6.0 | 3950 | |
| 5 | Дашинчилэн-Рашаант | 75 | 17 | 12.8 | 3950 | |
| 6 | Рашаант-Гурванбулаг | 85 | 17 | 14.5 | 3950 | |
| 7 | Гурванбулаг-Могод | 108 | 17 | 18.36 | 3950 | |
| 8 | Могод -Хишиг-Өндөр | 95 | 17 | 16.2 | 3950 | |
| 9 | Хишиг-Өндөр-Булган | 70 | 17 | 11.9 | 3950 | |
| | **Дүн** | **650** | | **110.7** | 3950 | **437 265** |
| 10 | Булган -Сайхан | 110 | 17 | 18.7 | 3950 | |
| 11 | Сайхан-Баян-Агт | 75 | 17 | 12.8 | 3950 | |
| 12 | Баян-Агт-Хутаг-Өндөр | 88 | 17 | 15 | 3950 | |
| 13 | Хутаг-Өндөр-Тэшиг | 114 | 17 | 19.5 | 3950 | |
| 14 | Тэшиг-Булган | 250 | 17 | 42.5 | 3950 | |
| | **Дүн** | **634** | | **108.5** | 3950 | **428 600** |
| 15 | Булган-Бугат | 55 | 17 | 9.3 | 3950 | |
| 16 | Бугат-Сэлэнгэ | 106 | 17 | 18.0 | 3950 | |
| 17 | Сэлэнгэ-Хялганат | 45 | 17 | 7.7 | 3950 | |
| 18 | Хялганат-Хангал | 40 | 17 | 6.8 | 3950 | |
| 19 | Хангал-Булган | 114 | 17 | 19.4 | 3950 | |
| | **Дүн** | **359** | | **61.3** | 3950 | **242 135** |
| | **Нийт** | **1643** | | **280** | 3950 | **1 108 000** |